

2024

ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ


Хэзээ: 2024.04.29

Хаана: “Монгол Даатгал” ХК-ийн төв байр,
3-р давхар хурлын танхим



АГУУЛГА

1. “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 24/08 тоот тогтоол
 - “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудас
 - “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
 - “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын баримт бичгийн жагсаалт
 - “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
 - “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
2. “Монгол Даатгал” ХК-ийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
 - Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
 - Хөндлөнгийн аудитын дүгнэлт
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийн санал
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
5. “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолын төсөл
6. “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд



**“Монгол Даатгал” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах
тухай Төлөөлөн удирдах
зөвлөлийн шийдвэр**

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**20 **24** оны **03** сарын **20** өдөрДугаар **24** /08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60, 65, 67, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, 76.1.11 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Төлөөлөн удирдах зөвлөлийн эцнээ хураасан саналын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Монгол Даатгал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, "Монгол Даатгал" ХК-ийн байранд 3 давхарт хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Монгол Даатгал ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2. Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 2.3. 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын зардлын төсвийг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлэх өдрийг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, мөн оны 04 дүгээр сарын 09-ний өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компаниудад хүргүүлэх, 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр болон 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд өдөр тутам гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевиз, компанийн вэбсайт, социал хуудсаар мэдээлэх зэргээр

Бууцаж авах: +976 7010-1990
Даргалын өвчлөх: +976 1000-1990www.mongoldaatgal.mn
info@mongoldaatgal.mn

- хурлын мэдэгдэл, зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.
 - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хуулбар;
 - 6.2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, тэдгээрийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
 - 6.3. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл танилцуулга;
 - 6.4. Хурлын санал хураах хуудас;
 - 6.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;
 - 6.6. Хурлын зар
 - 6.7. Хөндлөнгийн аудитын дүгнэлт
 7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар, хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, танилцах бичиг баримтын жагсаалтыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын зарыг Дөрөвдүгээр хавсралтаар, Тооллогын комиссыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
 8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 12 цагаар тогтоосугай.
 9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн гишүүн Базарын Аюушд даалгасугай.
 10. Хурал зохион байгуулах комиссын даргаар Т.Цацралыг томилсугай.
 11. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Т.Цацрал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДРИЙН “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ” №24/08 ТОГТООЛЫГ БАТАЛСАН:



№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Громов С.Б.			
2	О.Цогт			
3	Б.Аюуш			
4	З.Хайдар			
5	Л.Төр-Од			
6	Огай Н.Ю.			
7	Л.Таня			
8	Громов Б.С.			

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
24/08 тоот тогтоолын Хэвсрэлт №07



**"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

"Монгол Даатгал" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, "Монгол Даатгал" ХК-ийн байранд, 3 давхрын хурлын танхимд хуралдана.

1. Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____
2. Регистрийн дугаар: _____
3. Санал өгөх хувьцааны тоо: _____
4. Хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансны дугаар: _____
5. Үйлчилсэн ҮЦК-ийн нэр: _____
6. Үйлчилсэн ҮЦК-ийн ажилтны овог, нэр: _____

№	Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Монгол Даатгал ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ /...../

Санал авах хуудсыг үйлдсэн 2024 онысарын-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга _____ /...../

Хүчингүйд тооцсон бол

шалтгаан: _____

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
24/08 тоот тогтоолын Хэвсрэлт №01



**"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

1. Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____
2. Регистрийн дугаар: _____
3. Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____
4. Эзэмшиж буй хувьцааны тоо: _____
5. Хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансны дугаар: _____
6. Үйлчилсэн ҮЦК-ийн нэр: _____
7. Үйлчилсэн ҮЦК-ийн ажилтны овог, нэр: _____

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		
4		
5		
6		

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____/...../

Санал авах хуудсыг үйлдсэн 2024 онысарын-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол

шалтгаан: _____

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
24/08 тоот тогтоолын Хавсралт №01



Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудсыг нь хүчингүйд тооцогдоно.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо санал өгөх кумулятив аргыг ашиглана. Энэ аргаар саналаа өгөхдөө эзэмшиж буй хувьцааныхаа тоог 6-аар үржүүлж гарсан тоог ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнд дурын харьцаагаар хувааж өгнө. Харин хувьцааныхаа тоог 3-аар үржүүлж гарсан саналын тоог хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 3 хүнд дурын харьцаагаар хувааж саналаа өгнө. Тухайлбал, таны эзэмшиж буй хувьцааны тоо 100 гэвэл 600 саналыг ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнээс нэг хүнд бүгдийг нь өгч болно, эсвэл нэгэнд нь 500 саналаа 2 дахад нь 100 саналаа гэх мэтээр ямар ч харьцаагаар хувааж өгч болно. 300 саналаа хараат бус гишүүнд нэр дэвшиж буй нэг хүнд бүгдийг нь эсвэл 3 хүнд адилхан 100 санал өгөх мэтээр хувааж өгч болно. Гэхдээ хараат бус гишүүнд нийт саналынхаа 1/3-ыг ердийн гишүүнд нийт саналынхаа 2/3-ыг өгсөн байх ёстой. Ингээгүй бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө. Энэ тохиолдолд саналын хуудсыг хүлээн авсан брокер гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.
4. Хэрэв саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог нэр, хаягийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болгон үнэт цаасны хадгаламжийн дансны хуулгыг хамт өгч явуулна.

Таны төлөөлөх хүний овог: нэр:.....

Оршин суугаа хаяг:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 94001934 утсаар лавлаж болно.

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
24/08 тоот тогтоолын Хавсралт №02



**"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр
Байршил: Монгол Даатгал ХК-ийн хурлын танхимд
Цаг: 12:00

№	Хэлэлцэх асуудлууд	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх /Тооллогын комисс/	12:00-12:30
2	Хурлын ирцийг мэдээлэх, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулах /Тооллогын комиссын дарга/	12:30-12:35
3	Хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах /Хурлын дарга/	12:35-12:40
4	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх /ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Л.Төр-Од/	12:40-13:00
5	Асуулт, хариулт	13:00-13:05
6	Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулах /Хурлын дарга/	13:05-13:20
7	Цайны завсарлага	13:20-13:35
8	2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын зардлын төсвийг хэлэлцэх /ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Л.Төр-Од/	13:35-13:45
9	Асуулт, хариулт	13:45-13:50
10	Хэлэлцэж буй асуудлаар санал хураах /Хурлын дарга, Тооллогын комиссын дарга/	13:50-13:55
11	Тооллогын комиссын дүн болон тогтоолыг уншиж танилцуулах /Тооллогын комиссын дарга/	13:55-14:00
12	Хурлаас гарах хувьцаа эзэмшигчдийн шийдвэр тогтоолыг уншиж танилцуулах /Хурал зохион байгуулах комиссын дарга/	14:00-14:05
13	Хурлын дарга хурлыг хаах	14:05-14:10

Хурал зохион байгуулах комисс

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
24/08 тоот тогтоолын Хэвсрэлт №03



**"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ
ХУРАЛДУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 24/08 тоот тогтоол
2. Монгол Даатгал ХК-ийн 2023 оны санхүү болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
 - Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
 - Хөндлөнгийн аудитын дүгнэлт
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
24/08 тоот тогтоолын Хавсралт №04



**"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

Компанийн нэр: "Монгол Даатгал" ХК

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 12:00 цагт
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, "Монгол даатгал"
ХК-ийн байранд 3 давхрын хурлын танхим

**Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийн
жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. "Монгол Даатгал" ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. "Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож, батлах;
3. 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах;

**Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт
бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:**

- Хувьцаа эзэмшигчид 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандах компанийн цахим хуудсаар www.mongoldaatgal.mn эсвэл компанийн байранд ирж, хурал зохион байгуулах комиссын дарга Т.Цацралд мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцаж болно.
- Саналын хуудсаа бөглөж ирүүлэх зааврыг цахим хуудаст www.mongoldaatgal.mn тавигдсан мэдээллээс авна уу.
- Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гарагт 08:00 -15:00 цагийн хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын даргын мэдээлэл:

Дарга: Овог нэр: Түдэв Цацрал
Цахим шуудангийн хвөг: Tsetsral.T@mongoldaatgal.mn
Утас: 9400-1934

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
24/08 тоот тогтоолын Хэвсрэлт №05



**"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС**

КОМИССЫН ДАРГА:

Ө.Эрдэнэбилэг


КОМИССЫН ГИШҮҮН:

Д.Дашпүрэв



2023

ЖИЛИЙН
ТАЙЛАН



КОМПАНИЙН СТРАТЕГИ



АЛСЫН ХАРАА

Даатгалын иж бүрэн үйлчилгээг айл өрх, албан байгууллага бүрд хүргэсэн дэлхийн жишиг компани байна.




ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагч төвтэй, мэргэшсэн, ёс зүйтэй даатгалын үйлчилгээг шилдэг шийдлээр хүртээмжтэй хүргэж, итгэлтэй ирээдүйг бүтээлцэнэ.



ҮНЭТ ЗҮЙЛС

Харилцагчийн сэтгэл ханамж
Мэргэжлийн өндөр ур чадвар, ёс зүй
Инноваци, шинийг санаачлах,
Өөриймсөг хандлага
Нийгмийн хариуцлага



ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- Ёс зүй
- Өөриймсөг сэтгэлтэй
- Өөрэг хандлагатай
- Суралцагч
- Аз жаргалтай ажилтан
- Багаар ажиллах
- Шийдвэрлэх чадвартай
- Хурдтай ажиллах
- Бүтээмжтэй
- Инновацлаг

ЛОГОНЫ БЭЛГЭДЭЛ



ДҮРСНИЙ БЭЛГЭДЭЛ

Даатгалын салбарын өв уламжлалыг хадгалагч компанийн хувьд Монгол түмний гэр сууц бүхий бэлгэдлийг энэхүү сүлд тэмдэгтээ хадгалж, уг гэр сууцыг бид айл өрх, аж ахуй нэгжээр төлөөлүүлсэн бөгөөд манай үйл ажиллагаа нь хоёр давхар хамгаална гэсэн бат илэрхийллийг дүрсэллээ.



Айл өрх
Аж ахуйн нэгж



Уул мэт
түшигтэй



Хоёр давхар
хамгаалагдсан



Бат бэх суурь
итгэлтэй



ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ

Монгол түмний бахархал, хүндэтгэл шингэсэн гэр сууцыг мөнх хөх тэнгэр, эдийн эх хадгийн цэнхэр өнгөөр илэрхийлсэн нь харилцагчдадаа ямагт дээдэлж, тэдний тайван амгалан амьдралын төлөө зүтгэж, итгэлцэл, үнэнч байдлыг аливаа харилцаандаа нягт тусгаж ажиллахыг бэлгэдлээ.



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Даатгал Компани нь 1934 онд тулганы чулуугаа тавьж үйл ажиллагаагаа эхлүүлсэн цагаасаа хойш даатгалын үйлчилгээг ард иргэддээ үзүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг ямагт харилцагч нарын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан эрсдэлийг хамгаалсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол хөгжүүлэн салбарын тэргүүлэгч, чиглүүлэгч байсаар ирсэн.

Бид орон даяар үйл ажиллагаа явуулж буй 29 салбар нэгж, 670 төлөөлөгчөөрөө дамжуулан, Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон сайн дурын даатгалын 14 хэлбэр, албан журмын даатгалын 1 хэлбэрийн хүрээнд нийт 76 даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэн зах зээл дээр худалдан борлуулах эрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

1934 онд анх гал голомтоо бадрааж, Монголын ууган даатгалын компани болж байгуулагдсан цагаас хойш 90 жилийн амжилтаар дүүрэн, баялаг түүхийг хамтдаа цогцлоож буй хамт олон, хамтрагчтуншүүд, ард иргэддээ чин сэтгэлээсээ талархаж буйгаа илэрхийлье.

Монгол Даатгал ХК нь Улаанбаатар хот, 21 аймаг дахь салбар болон 600 гаруй төлөөлөгчөөрөө дамжуулан харилцагч, даатгуулагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн эрсдэлийн удирдлагын шийдэл бүхий мэргэжлийн түвшний чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч ажиллахын зэрэгцээ харилцагчдынхаа эрсдэлийг бүрэн хариуцах үүднээс дэлхийн нэр хүнд бүхий давхар даатгалын олон компаниудтай хамтран ажиллаж байна. Ирэх 5 жилд бид Монголдоо олон улсын жишигт нийцсэн даатгалын үйлчилгээтэй байгууллага болох алсын хараатай ажиллаж байгаа билээ.

Өнөөдөр бид ажилтнуудынхаа ажиллах нөхцөлийг сайжруулж, ажлын цагийн уян хатан хуваарийг нэвтрүүлж, эмэгтэй ажилтнуудын өдрийн ажлын хугацааг 6 цаг болгосон ба цаашид нийт ажилтнуудын ажлын цагийг 6

болгон олон улсын хандлагыг нэвтрүүлэн ажилтнуудынхаа төлөө улам ихийг бүтээж, даатгуулагч иргэд, байгууллагууддаа чанартай, итгэлтэй үйлчилгээг үзүүлэхийн төлөө томоохон зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Ойрын ирээдүйд бүх ажилтнууддаа компанийн хувьцааг эзэмшүүлж, цаашлаад хамтрагч түншүүд, харилцагчдаа Монгол Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигч болгож, хамтран ажиллах болно.

Компанийнхаа 90 жилийн түүхт ойн мэндчилгээг өнөөг хүртэл хамтран ажиллаж буй ажилтнууд, харилцагчид, иргэддээ хүргэхийн ялдамд сэтгэл зүтгэлтэй, ажилч хичээнгүй хамт олныхоо хүчээр амжилтын түүхээ өртөөлсөөр, хүмүүний итгэлт ирээдүй, амар тайван амьдралын төлөө бодит хөгжил дэвшлийг цаашид эх орондоо цогцлоон бүтээсээр байх болно гэдгээ илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,
Гүйцэтгэх захирал

Л.Төр-Од

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Сайн засаглалын олон улсын шалгарсан практикуудыг нутагшуулж, засаглал, менежментийн эрүүл зөв тогтолцоог хэрэгжүүлэх нь Монгол Даатгалын эрхэм зорилгын чиглүүлэгч юм.


Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлснээр компанийн үйл ажиллагаа тогтвортой явагдах, бие даасан хараат бус, чанартай шийдвэр гаргах боломж бүрдэхээс гадна цаашдын тасралтгүй өсөлт хөгжилтөд эергээр нөлөөлдөг юм.

Монгол Улсын тэргүүлэгч даатгалын компанийн хувьд бид компанийн засаглалын туршлагыг сайжруулж, эрүүл зөв тогтолцоог бий болгохын тулд компанийн засаглалын өнөөгийн түвшин, шаардлагатай өөрчлөлтүүдийг тодорхойлж, компанийн засаглалын бодлого журмыг боловсронгуй болгохоор ажиллаж байна.



ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь нийт есөн гишүүнээс бүрддэг бөгөөд гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас жил бүр сонгон томилдог.



ГРОМОВ С.Б.
ТУЗ-ийн дарга

Громов Сергей Борисович нь 2001 оноос хойш банк санхүү, даатгалын салбарт тасралтгүй ажиллаж 2001-2016 он хүртэл "Чингис Хаан" банкны ТУЗ-ийн дарга, 2004 оноос одоог хүртэл "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.



Б. АЮУШ
ТУЗ-ийн гишүүн

Базарын Аюуш нь Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, эрхзүйч эдийн засгийн ухааны доктор зэрэгтэй. Мандах дээд сургуульд зөвлөх профессор, Райнос ассет менежмент компанид ахлах аудитораар ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 12-р сараас эхлэн "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.




О. ЦОГТ
ТУЗ-ийн гишүүн

Очиржанцангийн Цогт нь Инженер эдийн засагч, татвар санхүүгийн чиглэлээр ОХУ, Япон улсад суралцсан бөгөөд "Хүлэг консалтинг ТМЗ" ХХК-д татварын зөвлөхөөр ажиллаж байна.



З. ХАЙДАР
ТУЗ-ийн гишүүн

Зоригийн Хайдар нь санхүү, эдийн засагч мэргэжилтэй бөгөөд 2023 оны 8 дугаар сараас эхлэн "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.




Огай Наталья Юрьевна хэл зүйч, санхүүч мэргэжилтэй. ОХУ болон Монгол улсад банк, санхүү даатгалын чиглэлээр 2003 оноос хойш тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оноос одоог хүртэл ажиллаж байна.



Таня Лизунова нь МУИС-д санхүү эдийн засгийн чиглэлээр суралцан төгсөж, 2006 оноос хойш "Чингис Хаан" банкны ТУЗ-ийн туслах, 2016 оноос хойш "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.




Лхагважавын Төр-Од нь 2005-2006 он Англи улс Лондон хотын Лондон Их сургуулийн Дорно дахин, Африк судлалын сургуулийг Олон улсын хууль зүй, Хөгжлийн эдийн засгийн Хууль зүйн магистрын онц зэрэгтэй суралцаж төгссөн. 1992-1997 он Энэтхэг улсын Хууль зүйн Үндэсний их сургуулийг Эдийн засгийн бакалавр, Хууль зүйн бакалавр, 1991-1992 он МУИС, ШУА-ны Хууль зүйн сургалт, судалгааны хүрээлэн, 1998 оноос эхлэн удирдах албан тушаалд ажилласан туршлагатай бөгөөд одоо "Монгол Даатгал" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Громов Борис Сергеевич нь санхүүч мэргэжилтэй, CFA институтийн гишүүн, CFA зэрэгтэй, 2016 оноос удирдах албан тушаалд ажилласан бөгөөд Galyandar ХХК-ийн захирал, Ауа enterprises ХХК-ийн захирлаар тус тус ажиллаж байна.

КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



УДИРДЛАГЫН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Даатгал ХК-ийн удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, ажлын туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн компанийн урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.



Л.ТӨР-ОД

Гүйцэтгэх захирал

Лхагважавын Төр-Од нь 2005-2006 он Англи улс Лондон хотын Лондон Их сургуулийн Дорно дахин, Африк судлалын сургуулийг Олон улсын хууль зүй, Хөгжлийн эдийн засгийн Хууль зүйн магистрын онц зэрэгтэй суралцаж төгссөн. 1992-1997 он Энэтхэг улсын Хууль зүйн Үндэсний их сургуулийг Эдийн засгийн бакалавр, Хууль зүйн бакалавр, 1991-1992 он МУИС, ШУА-ны Хууль зүйн сургалт, судалгааны хүрээлэн, 1998 оноос эхлэн удирдах албан тушаалд ажилласан туршлагатай бөгөөд одоо "Монгол Даатгал" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Б.НАМЖИЛСҮРЭН

Бизнес хөгжил, салбарын удирдлагын ерөнхий менежер

Базарваанийн Намжилсүрэн нь Төрийн удирдлага, Байгууллагын хөгжил, хүний нөөцийн удирдлагаар мэргэшсэн. ЗХУ-ын Новосибирск хотын Цахилгаан холбооны дээд сургуулийг "Цахилгаан холбооны инженер"-ээр магистрын зэрэгтэй суралцаж төгссөн. 2019 оноос эхлэн удирдах албан тушаалд ажилласан туршлагатай бөгөөд одоо "Монгол даатгал" ХК-д Бизнес хөгжил, салбарын удирдлагын ерөнхий менежерээр ажиллаж байна.



Б.НАРАНТУЯА

Ерөнхий нягтлан бодогч

Баатарын Нарантуяа нь Санхүү эдийн засаг, техникумыг Санхүүч-Эдийн засагч, Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Нягтлан бодогч, бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. 2012 онд Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч гэрчилгээ авсан. Тус салбарт нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч зэрэг удирдах албан тушаалд ажилласан туршлагатай. 1992 оноос хойш "Монгол даатгал" ХК-д ажиллаж байна. 2023 оноос Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байна.



Б.НАРАНГОО

Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

Барамсайгийн Нарангоо нь Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн "Хүний нөөцийн менежмент"-ийн магистрын зэрэгтэй суралцаж төгссөн. Тус салбарт Хүний нөөцийн менежер, Хүний нөөцийн ахлах менежер зэрэг албан тушаалд ажилласан туршлагатай. 2013 оноос хойш "Монгол даатгал" ХК-д ажиллаж байна. 2023 оноос Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаар дэвшин ажиллаж байна.



Г.ГАНЖАРГАЛ

Эрүүл мэндийн даатгал хариуцсан дэд захирал

Гантөмөрийн Ганжаргал нь БНХАУ-ын Бээжин хотод Олон улсын бизнес, эдийн засгийн их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр магистрын зэрэгтэй суралцаж төгссөн. Төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын төсөл зэрэгт ажиллаж байсан туршлагатай. "Монгол даатгал" ХК-д 2017 оноос хойш Эрүүл мэндийн даатгал хариуцсан ажиллаж байна.



Ч.БАТНАРАН

Салбар хариуцсан дэд захирал

Чулуунбатын Батнаран нь Монгол улсын их сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй. Тус салбарт нягтлан бодогч, удирдах албан тушаалд ажилласан туршлагатай. 1995 оноос хойш "Монгол даатгал" ХК-д ажиллаж байна. 2023 оноос Салбар хариуцсан дэд захирлаар дэвшин ажиллаж байна.



Б.ЧИНГҮҮН

Эрсдэл, дотоод хяналт, комплаенс хариуцсан дэд захирал

Батхуягийн Чингүүн нь Монгол улсын их сургуулийг Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй суралцаж төгссөн. Тус салбарт Хуульч, хуулийн зөвлөх, Комплаенс хариуцсан захирал зэрэг албан тушаалд ажилласан туршлагатай. 2023 оноос хойш "Монгол даатгал" ХК-д Эрсдэл, дотоод хяналт, комплаенс хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.



Г.УУГАНБИЛЭГ

Хууль зүй, тусгай актив хариуцсан дэд захирал

Гантөгсийн Ууганбилэг нь Их засаг олон улсын их сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй суралцаж төгссөн. Өмгөөлөгч, Хуульч, Хууль, тусгай активын чиглэлээр ажилласан туршлагатай. 2023 оноос хойш "Монгол даатгал" ХК-ийн Хууль зүй, тусгай актив хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.




Г.НАРМАНДАХ

Харилцагчийн үйлчилгээ, нөхөн төлбөр хариуцсан дэд захирлын үүрэг гүйцэтгэгч


Гонгорын Нармандах нь Компьютер, өндөр технологийн цахим сургуулийг Бизнесийн удирдлагаар бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. Тус салбарт Шуурхай албаны ажилтан, нөхөн төлбөрийн менежер, нөхөн төлбөрийн ахлах менежер зэрэг албан тушаалд дэвшин ажилласан туршлагатай. 2012 оноос хойш "Монгол даатгал" ХК-д ажиллаж байна. 2023 оноос Харилцагчийн үйлчилгээ, нөхөн төлбөр хариуцсан дэд захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байна.

ТҮҮХЭН ТОВЧОО



2023 ОНЫ ЭДИЙН ЗАСАГ, САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

2023 оны байдлаар ердийн даатгагчдын нийт хөрөнгө **469 тэрбум төгрөг** болж 18%-иар өссөн бол нийт хураамжийн орлого **389 тэрбум төгрөг** болж өмнөх оны мөн үеэс 30%-иар өссөн үзүүлэлттэй байна. Харин даатгалын салбарын нөхөн төлбөрийн хэмжээ 46%-иар өсөж **119 тэрбум төгрөг** болсон байна.



САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	2020	2021	2022	2023
Нийт актив	382	354.5	398.2	469.0
Өөрчлөлт %	4%	-7%	12.3%	17.8%
Нийт хураамжийн орлого	205	242.2	297.9	388.9
Өөрчлөлт %	4%	18%	23%	30.5%
Даатгалын гүнзгийрэлт, хувиар	0.55%	0.56%	0.57%	0.56%
Нөхөн төлбөр	55.8	67.4	92.8	119.3
Өөрчлөлт %	-13%	21%	37.6%	45.8%

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР

7.7 ТЭРБУМ

2023

НИЙТ НӨӨЦ САН

17.9 ТЭРБУМ

2023

НИЙТ ХУРААМЖ

30.4 ТЭРБУМ

2023

НИЙТ ХӨРӨНГӨ

35 ТЭРБУМ

2023

НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР

8.7 ТЭРБУМ **7.4** ТЭРБУМ **7.7** ТЭРБУМ



2021 2022 2023

НИЙТ ХУРААМЖ

29.2 ТЭРБУМ **27.1** ТЭРБУМ **30.4** ТЭРБУМ



2021 2022 2023

НИЙТ НӨӨЦ САН

21.1 ТЭРБУМ **18.4** ТЭРБУМ **17.8** ТЭРБУМ



2021 2022 2023

НИЙТ ХӨРӨНГӨ

37 ТЭРБУМ **37.4** ТЭРБУМ **35** ТЭРБУМ



2022 2022 2023

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

/Баланс, сая төгрөгөөр/

БАЛАНС	2021	2022	2023
Эргэлтийн хөрөнгө	27,088	27,509	25,138
Эргэлтийн бус хөрөнгө	9,959	9,974	9,954
Үндсэн хөрөнгө	8,598	8,614	8,592
Нийт хөрөнгө	37,047	37,483	35,092
Нийт өр төлбөр	22,968	23,238	22,410
Богино хугацаат өр төлбөр	1,866	4,781	4,542
Нөөц сан	21,102	18,458	17,869
Эзэмшигчийн өмчийн дүн	14,078	14,245	12,682
Нийт өр төлбөр ба Өмч	37,047	37,483	35,092


ОРЛОГЫН ТАЙЛАН

/Орлогын тайлан, сая төгрөгөөр/


ОРЛОГЫН ТАЙЛАН	2021	2022	2023
Даатгалын хураамжийн нийт орлого	29,223	27,196	30,410
Даатгалын хураамжийн цэвэр орлого	15,595	14,564	17,446
Нийт нөхөн төлбөрийн зардал	8,778	7,495	7,713
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	8,369	6,922	6,602
Хөрөнгө оруулалтын олз, гарз	3,001	358	449
Даатгалын үйл ажиллагааны ашиг(алдагдал)	8,111	9,712	7,666
Нийт зардал	10,779	12,296	12,245
Бусад ашиг (алдагдал)	7,795	-9,377	-9,136
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	316	335	1,470
Орлогын албан татварын зардал	202	169	92
Татварын дараах ашиг (алдагдал)	114	166	-1,562

МОНГОЛ ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ


НИЙТ ХӨРӨНГӨ




НИЙТ ХУРААМЖ



НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР



НӨӨЦ САН



АНДЕРРАЙТИНГ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



"Монгол Даатгал" ХК-ийн Эрсдэл, дотоод хяналт, комплаенсийн удирдлагын газар нь эрсдэл, дотоод хяналт, комплаенс хариуцсан дэд захирал, ахлах актуарч, дотоод хяналт, комплаенсийн ахлах менежер, комплаенсийн ахлах хуульч гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд ахлах актуарч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос /Хороо/ актуарын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Эрсдэл, дотоод хяналт, комплаенсийн удирдлагын газрын үндсэн гүйцэтгэх үүрэг, зорилго нь даатгагчийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэх бөгөөд даатгагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох аливаа эрсдэлээс зайлсхийх, бууруулах арга хэмжээг авч ажиллахдаа холбогдох хууль, хорооны журам болон компанийн бодлого, журамд нийцүүлэн ажилладаг. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн гурван шатлалт хамгаалалтыг ашиглаж компанийн удирдлагын багт эрсдэлтэй нөхцөл байдлын талаар тухай бүр тайлагнаж, эрсдэлийг бууруулах,

эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аван ажиллаж байна.

Компанийн бүх шатны ажилтан өөрийн хариуцсан ажилтай холбогдон гарах эрсдэлийг хариуцах хариуцагч нь байх бөгөөд тус бүрийн ажлаа хийж гүйцэтгэх явцад гарах мөнгөн болон мөнгөн бус хохирлоос урьдчилан сэргийлнэ. Нэгдүгээр шатны эрсдэлээс давсан эрсдэл буюу тухайн ажилтан, газар нэгжүүд урьдчилан хараагүй, тооцоолоогүй эрсдэл нь бодитоор компанид хохирол учруулж эхэлсэн үед эрсдэлийн удирдлагын алба тухайн эрсдэлүүдийг тодорхойлж, хэмжиж, бууруулах арга замыг олж холбогдох нэгжүүд, удирдлагуудад мэдээлж, тайлагнаж ажилладаг. 2023 онд санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх эрсдэл, андеррайтингийн үйл ажиллагааны эрсдэлд түлхүү анхаарал хандуулан зөвлөмж анхааруулга өгч ажилласан бөгөөд өмнөх жилд авч хэрэгжүүлж байсан ажлуудыг мөн үргэлжлүүлэн ажиллаж байна.

АНДЕРРАЙТИНГИЙН ЭРСДЭЛ



Андеррайтингийн эрсдэл нь дотроо даатгалын гэрээ нөхцөл, хураамжийн хувь, нөхөн төлбөр зэргийг багтаасан өргөн агуулгатай эрсдэл юм.

- Алдагдалтай байгаа борлуулалтын суваг, харилцагчийн хувьд дүн шинжилгээ хийн учир шалтгааныг тодруулан, зарим гэрээг сайжруулан, зарим гэрээний сунгалтыг цуцалсан.
- Улирал бүр даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр хохирлын харьцааны динамик гарган удирдлагын багт танилцуулдаг. Ингэснээр аль бүтээгдэхүүн дээр илүү төвлөрч борлуулалт хийх, аль бүтээгдэхүүний нөхцөлд сайжруулалт хийх шаардлагатай байгаа зэрэг оновчтой шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлж байна.

ХУРААМЖИЙН ЭРСДЭЛ



Даатгалын зах зээл нь банкны салбартай харьцуулахад хэдэн зуудахин бага зах зээл юм.

Энэ зах зээлд 15 ердийн даатгалын компани үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой өрсөлдөөн их байдаг. Компаниудын гол өрсөлдөх талбар нь хураамжийн хувь бөгөөд хэн бага үнийн санал өгсөн нь гэрээг байгуулдаг буруу жишиг бий болоодуудаж байна.

Уг эрсдэлийг удирдах ажлын хүрээнд хураамжийн хувь нь жил дараалан бууж байгаа харилцагчдыг олж тогтоох, хураамжийн уналтыг зогсоох, зарим тохиолдолд өсгөх шаардлагыг даатгалын борлуулалтын нэгжид хүргэн ажиллаж байна.

НӨӨЦ САНГИЙН ЭРСДЭЛ



Даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Улирал бүр хорооны багц журмын гуравдугаар хавсралтын дагуу Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан, Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн тооцоолол хийж тайлан бэлтгэн хороонд хүргүүлдэг. Нөөц санг даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахуйц буюу хангалттай хэмжээнд байгуулан, тасралтгүй өсөн нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.

ӨӨРИЙН ЭРСДЭЛ



Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлангийн хүрээнд байгууллагад учирч болзошгүй гол эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэл тус бүрийг хэмжих харьцаа үзүүлэлтүүдийг сонгон эрсдэлийн аппетит болон эрсдэл хүлцэх чадваруудыг тодорхойлсон. Мөн эрсдэл бүр дээр эрсдэл даах хязгаараас давсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулан тайланд тусгасан болно.



Эрсдэлд суурилсан хөрөнгийн хүрэлцээний харьцааны тооцоололд компанид гэнэтийн эрсдэл учрахад ашиглах боломжтой зөвшөөрөгдөх хөрөнгө болон ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдийг тооцоолж гаргасан зайлшгүй байх хөрөнгүүдийг санхүү байдлын тайлан дээр болон бусад эхүүсвэрийг ашиглан тооцоолсон.



Актуарын хянан шалгалтын тайлан. Хорооны журмын дагуу заасан хугацаанд нөөц сангийн хүрэлцээ, санхүүгийн тогтвортой байдлын талаар актуарын хянан шалгалтыг тайланг бэлтгэн удирдлагын хороонд танилцуулж, хороонд хүргүүлсэн.



Хураамж тооцоолох үйл ажиллагаа. Шинээр зах зээлд гаргаж буй бүтээгдэхүүн, эсвэл хуучин бүтээгдэхүүнийг шинэчлэн гаргаж хороонд бүртгүүлэхэд хураамжийн актуар тооцоолол хийх шаардлагатай байдаг.

ДАВХАР ДААТГАЛ

Бид хүлээн авсан эрсдэлээ үнэлэн, шинжилгээ хийж, өөрийн төлбөрийн чадвар, эдийн засгийн чадавх, макро эдийн засгийн өөрчлөлт, хандлагатай уялдуулан дэлхийн томоохон, нэр хүндтэй давхар даатгагч нарт эрсдэлийн багцаа Трити болон факультатив байдлаар нэг бүрчлэн давхардаатгуулдаг.

Бид давхар даатгагчдын санхүүгийн найдвартай байдлыг нэн түрүүнд чухалчлан, санхүүгийн хүчин чадлын үнэлгээгээр A.M.Best "A-", S&P "BBB"-ээс дээш үнэлгээтэй нэр хүнд бүхий зах зээлд тэргүүлэгч давхар даатгагчаар даатгуулдаг. Манай факультатив давхар даатгалын эрсдэлийг Их Британи, Герман, Сингапур, Хон-Конг, Швейцарь улсад байрласан санхүүгийн хүчин чадлын зэрэглэл тогтоогч Standard & Poor's, A.M.Best, Fitch-ийн өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын компаниуд хүлээн авдаг.

Дэлхийд нэр хүндтэй, өндөр үнэлгээтэй, томоохон давхар даатгагч нар нь манай эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэхээс гадна, харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт болон түргэн шуурхай үйлчилгээ авах боломжоор хангаж байгаа юм.

Давхар даатгах нөхцөлүүд:

5 сая ам.доллар хүртэлх үнэлгээтэй даатгалын гэрээнүүдийг багцын давхар даатгалын гэрээний дагуу автоматаар хамгаалалтад багтана.

Багцын давхар даатгалын хамгаалалтаас давсан өндөр үнэлгээ бүхий эсвэл онцгой төрлийн үйл ажиллагаа явуулдаг харилцагчидтай факультатив давхар даатгалын гэрээг байгуулна.

Олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг дэлхийн нэр хүндтэй, даатгалын зах зээлд тэргүүлэгч давхар даатгалын компаниуд Allianz Worldwide Care, HannoverRe-тэй хамтран харилцагч нартаа хүргэж байна.

Гадаад зорчигчдын гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг дэлхийн нэр хүндтэй, даатгалын зах зээлд тэргүүлэгч A.M.Best –ээс A+ зэрэглэл бүхий давхар даатгалын компаниуд XL Re Europe SE, Odyssey Reinsurance Company, болон Swiss Life Prevoyance-тай хамтран харилцагч нартаа хүргэж байна.

Бид хүлээн авсан эрсдэл бүртээ шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд давхар даатгалын хамгаалалтаар бүрэн хангаж харилцагчдынхаа найдвартай түнш байх зорилгоо тогтмол биелүүлсээр байна.



ДААТГАЛЫН БОРЛУУЛАЛТ БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛЫН ГАЗАР

Монгол Даатгал ХК нь цаг ямагт салбартаа шинэлэг шийдлийг нэвтрүүлж, даатгуулагчдын хүсэл, шаардлагад нийцсэн даатгалын үйлчилгээг үзүүлж, Монголын топ аж ахуй нэгжүүдтэй хамтарч ажилласаар ирсэн. Бид барилга, уул уурхай, тээвэр, худалдаа үйлчилгээ, санхүү үйлдвэрлэлийн салбарын компаниудад нийт 70 гаруй бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож байна.



Бизнес тасалдлын
болон гэрээний
хариуцлагын даатгал



Захирал болон
удирдах ажилтны
хариуцлагын даатгал




Ажилтны эрүүл
мэндийн
даатгал



Барилга
угсралтын
ажлын даатгал



Үйлдвэрийн болон
оффисын барилгын
даатгал



Хүнд даацын болон
тусгай зориулалтын
машин механизмын
даатгал

ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТИЙН СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨ

Бид гэнэтийн эрсдэл, аюул, ослын үед учирч болзошгүй хохирлыг бууруулахад даатгуулагчдадаа өөрийн боловсон хүчин, Улсын Онцгой байдлын газар болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран практик сургалт зохион байгуулдаг. Тухайлбал, бид энэ чиглэлд АНУ, Япон, Орос зэрэг өндөр хөгжилтэй улсын мэргэжлийн байгууллагыг урьж сургалт зохион байгуулж байсан туршлагатай.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗӨВЛӨГӨӨ


Аливаа бизнест тулгарах алдагдал, хохирол, хор хөнөөлөөс сэргийлэхийн тулд эрсдэлийг эрт илрүүлж, удирдах нь чухал байдаг. Иймээс бид харилцагчдынхаа эрсдэлийн илрүүлж бодитой үнэлснээр түүнийг бууруулах, үр дүнтэй удирдахад нь ямагт онцгой анхаарал хандуулж холбогдох ажилтнуудад "ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЦОГЦ СУРГАЛТ"-ыг зохион байгуулдаг.

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагчдынхаа бизнесийн эрсдэлийг цаг алдалгүй тооцоолох, удирдахад өөрсдийн өргөн мэдээллийн зэрэгцээ судалгааны мэргэжлийн байгууллагатай хамтран тухайлсан салбаруудын эдийн засгийн нөхцөл байдал, хандлагыг судлан цогц хэлбэрээр мэдээлэл өгч ажилладаг.

СУВГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

Иргэдийн даатгалын зах зээл рүү тэмүүлсэн, цогц үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий тус газар нь 21 аймаг дахь салбарууд, банк зуучлал, даатгалын төлөөлөгч, брокер, шууд борлуулалтын нэгжийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Ард иргэд, аж ахуйн нэгжийн даатгалын хэрэгцээ шаардлагыг хангах бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай, чанартайгаар хүргэх, харилцагч даатгуулагчдад даатгалын мэдлэг, санхүүгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх хамтын ажиллагааг өргөжүүлэх үндсэн зорилготой. Даатгалын зах зээл өөрийн суурин байрших салбар, төлөөлөгчийн газраас гадна хамтын ажиллагаатай даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй арилжааны банк, түүний тооцооны төвүүд, брокер компаниудын салбаруудаар дамжуулан хамгийн өргөн сүлжээ үүсгэн харилцагч даатгуулагч нартаа хүрч, ойлртсон үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж байна.



90 ЖИЛИЙН
ТҮҮХТЭЙ



21 АЙМАГТ САЛБАРТАЙ
200,000 ХАРИЛЦАГЧ



ТУРШЛАГА
АНДЕРРАЙТИНГ, НӨХӨН ТӨЛБӨР



МОНГОЛ ОРНЫГ ХАМАРСАН
ДААТГАЛЫН ӨРГӨН СҮЛЖЭЭ



НАЙДВАРТАЙ БАЙДАЛ
ДАВХАР ДААТГАЛ




БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ӨРГӨН СОНГОЛТ

ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Монгол Даатгал ХК нь 2010 онд эрүүл мэндийн даатгалыг хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэх бодлогын хүрээнд эрүүл мэндийн төслийн багийг үүсгэн байгуулж улмаар 2011 онд олон улсын эрүүл мэндийн даатгалын гэрээг үзэглэсэн анхны ердийн даатгалын компани юм. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь зах зээлийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан эмчилгээний зардлын даатгалын бүтээгдэхүүнийг олон улсад болон дотоодод үйлчлэх төрлөөр зах зээлд гаргаж, харилцагчдад найдвартай, баталгаатай үйлчилгээг хүргэхийг эрмэлзэн ажилладаг.

БАГЦЫН СОНГОЛТ



Бид олон улсын түвшинд хөгжингүй орнуудад хэрэгжиж буй эмчилгээний зардлын даатгалын бүтээгдэхүүнийг даатгуулагч, харилцагч нарт санал болгож, эрүүл мэндээ хамгаалах, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, ирээдүйд тохиож болох гэнэтийн өвчлөлд санхүүгийн бэлтгэлтэй байж шаардлагатай эмчилгээ үйлчилгээг дээд зэргийн эмнэлэгийн байгууллагуудад дэлхийн аль ч улс оронд авах боломжоор ханган ажиллаж байна.

2021

Ковид-19 вакцины эрсдэлийн даатгалыг зах зээлд гаргав.

2020

Peak Re, Hannover Re, РосГосСтрах зэрэг олон улсын зэрэглэл бүхий Давхар даатгалын компаниудтай хамтын ажиллагааны хүрээг тэлэв.

2018

Бүтээгдэхүүний өргөн сонголт.

2017

Allianz Worldwide Care компанитай хамтран ажиллаж эхлэв.

2016

Хилийн чанадад хийгдсэн эрхтэн шилжүүлэн суулгах, тархины хавдар авхуулах зэрэг өндөр өртөг бүхий эмчилгээний зардлыг бүрэн төлөв.

2015

Анхны яаралтай нүүлгэн шилжүүлэх тохиолдлын дагуу даатгагчийг Улаанбаатараас Хонг Конг-руу онгоцоор зөөн тээвэрлэв.

2014

Дотоодын сүлжээ эмнэлгүүдийн хүрээг тэлэв.

2013

Германы давхар даатгалын Munich Re компанитай хамтран ажиллаж эхлэв.

2012

Анхны том хэмжээний нөхөн төлбөр гарч, нэг удаагийн тохиолдлоор 219 мянган доллар олгов.

2011

Бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, анхны даатгалын гэрээг байгуулав.


2010

Олон улсын эрүүл мэндийн даатгалын төсөл эхлүүлэв.


НӨХӨН ТӨЛБӨР, ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нөхөн төлбөрийн удирдлагын газар нь нөхөн төлбөрийн талаарх зөв зүйтэй, оновчтой бодлогыг гаргах, түүнийг хэрэгжүүлэх, харилцагч даатгуулагч нарт найрсаг, соёлтой, түргэн шуурхай үйлчлэх, нөхөн төлбөр олголтын хугацааг багасгаж ажиллах талаар бодлого боловсруулж, холбогдох хууль, дүрэм, даатгалын гэрээ, нөхцөл, журамд нийцүүлэн ажиллахыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна. Тус газар нь системийн хэмжээнд 21 аймаг, хотын 4 салбар болон төвийн бүхий л нөхөн төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авч түүнд хяналт тавин ажиллаж, хууль, эрх зүйн орчинд компанийг төлөөлж, нөхөн төлбөрийг хамгийн боломжит хугацаанд түргэн шуурхай олгож, эелдэг найрсаг үйлчилгээгээр харилцагч, даатгуулагчийн сэтгэл ханамжийг өндөрт байлгаж, нөхөн төлбөрийн үйлчилгээгээр дамжуулан даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулан ажиллаж байна.

Бид **2023 онд 32 бүтээгдэхүүнээр 7314 даатгалын нөхөн төлбөрийн тохиолдолд 7,713,057,801.95** төгрөгийг олгосон.



ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ /ОРОН НУТАГТ/



НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР

Тээврийн хэрэгслийн даатгал

1 тохиолдолд олгож буй дундаж нөхөн төлбөр
1,022,080₮



Жолоочийн албан журам



Тээврийн хэрэгсэл



Гэнэтийн осол, эрүүл мэнд

Жолоочийн заавал даатгал

1 тохиолдолд олгож буй дундаж нөхөн төлбөр
982,225₮



Хөрөнгө



Хариуцлага



Бусад

ШУУРХАЙ АЛБА

Монгол Даатгал ХК нь даатгалын ууган байгууллагын хувьд, улсдаа хамгийн хүчирхэг, хүний нөөцтэй, материаллаг бааз суурь нь тэргүүлэгч байж, даатгалын зах зээлд үргэлж анхдагч байдгийн хувьд 2006 онд анх удаа "Шуурхай алба"-ыг нээн ажиллуулж байсан бөгөөд өнөөг хүртэл 24 цагаар ослын үйлчилгээг хүргэсээр байна.

Монгол Даатгал ХК-ийн шуурхай алба нь 2023 онд нийт 25501 км замыг туулан 2619 удаагийн даатгалын тохиолдлыг газар очиж үзэн ослын дараах үйлчилгээг үзүүлсэн байна.



2619 

удаагийн даатгалын тохиолдлыг газар дээр нь очин ослын дараах үйлчилгээг үзүүлсэн байна.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан даатгалын үйлчилгээг борлуулалтын бүхий л сувгаар дамжуулан стандартын дагуу мэргэжлийн түвшинд хүргэхэд чиглэсэн сургалт, мониторинг хийх, харилцагчийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх замаар компани болон харилцагчийн хоорондын итгэлцлийн нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, аян хэрэгжүүлэн ажиллаж байна.

2023 онд дуудлагын төвийн 5 шугамд нийт **71328** дуудлага ирсэн буюу өдөрт **240-250** дуудлага хүлээн авч харилцагчдаа даатгалын бүхий л үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

ОСЛЫН ДУУДЛАГА



52,830

ИРГЭДИЙН ДААТГАЛ



18,852

БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ



4,634

ЭРҮҮЛ МЭНДИЙН



12

НӨХӨН ТӨЛБӨР



5,758



САНАЛ ХҮСЭЛТ



4,158

CHATBOT



ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ
ИЛҮҮ ХЯЛБАР, ИЛҮҮ ХУРДНААР



ХҮНИЙ НӨӨЦ

Монгол Даатгал ХК нь салбарынхаа түүчээ болж нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн бодлого, гадаад харилцаа, хүний нөөцийн бодлогоороо манлайлан компанийнхаа шинэчилсэн стратегитай холбоотойгоор хүний нөөцийн урт хугацааны зорилгоо тодорхойлон талант менежментийг хэрэгжүүлж байна. Тус бодлогын хүрээнд байгууллагын бүх салбар нэгжийг шаардагдах мэргэжилтэн, ажилтнаар хангах, тэднийг хариуцсан ажил үүргээ чанартай сайн гүйцэтгэх арга барилд сургах, байгууллагын дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд ажилтан бүр авьяас чадвар, мэдлэг туршлагаа бүрэн дүүрэн ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Ажилтнуудынхаа карьер хөгжлийг тасралтгүй, үр өгөөжтэй байлгах зорилгын дагуу босоо болон хөндлөн чиглэлд албан тушаалд дэвшүүлэн томилох бүхий л боломжийг нээлттэй болгон жендерийн эрхтэгш байдлын бодлогыг хэрэгжүүлэн, хүйсийн харьцааг тэнцвэртэй хангаж ажиллав.



Компанийн ололт амжилтын тулгуур болсон үнэ цэнтэй ажилтныхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, цалин хөлс, урамшууллын оновчтой системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилтан цалин хөлсөө нэмэгдүүлэх боломж нээлттэй шударга болсноор илүү сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл бүрдсэн.



АЖИЛЛАГСДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛУУД



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ

“Эрүүл биед саруул ухаан оршино” өдөрлөг зохион байгуулан ясны сийрэгжилт тодорхойлох, био энергийн аппарат, танита аппарат, шүдний эмчийн үзлэг, арьс, үсний оношилгоо, уламжлалтын эмчийн үзлэг хийв.



ИОГИЙН ХИЧЭЭЛ

Ажиллагсдынхаа эрүүл мэнд, амьдралын зөв дадал зуршилд анхаарч, дасгал хөдөлгөөн хийх боломжоор ханган 7 хоног бүрийн 3 өдөр тогтмол иогийн хичээлийг өглөө хийж байна.



ГАР УТАСНЫ ХӨНГӨЛӨЛТ

Байгууллагаас гар утасны дугаар олгож ярианы хөнгөлөлтөд хамруулна.



ХАНИАД БОЛОН ЭЛЭГНИЙ В, С ЭСРЭГ ВАКЦИН

Өвлийн улирлын ханиад томуугийн улирал эхэлсэн үед нийт ажилтнуудад ханиадны вакцин хийлгэв. Мөн элэгний В болон С вирусын эрт илрүүлэг хийн, ажилтнуудад В болон С вирусын эсрэг 3 тунт вакцин хамруулав.



ТӨРСӨН ӨДРИЙН ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ

Ажилтанд төрсөн өдрийн бэлэг болгон төрсөн өдрөөр нь цалинтай нэг өдрийн чөлөө олгож байна.



ӨДРИЙН ХООЛНЫ ХӨНГӨЛӨЛТ

Төв оффисын ажилтнуудын өдрийн хоолны 50 хувийн хөнгөлөлтэдэлнэ.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

Сургалт, хөгжлийн цогц моделийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сургалт, хөгжлийн оновчтой хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, байнгын тасралтгүй сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Ажилтнуудынхаа сургалт, хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын үр өгөөжийг тооцож, хэмжиж эхлэв. Сургалтын үр өгөөжийг тооцоолон цаашдын сайжруулах шаардлагатай процесс болон асуудлуудыг тодорхойлон үүний үр дүнд компанийн гүйцэтгэл, бүтээмжид эергээр нөлөөлж эхлэв.

- GSMi Институт “EQ ба Хувь хүний манлайлал”
- ХХОАТ тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан Монголын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг
- Costumer Business Development төв Орчин цагийн Борлуулалтын Удирдлага”, “Борлуулалтын 4 Зарчим”
- Үндэсний давхар даатгал “Батлан даалтын эрсдэлийн үнэлгээ”
- OBSERVECONSALTING зөвлөх үйлчилгээний байгууллагын харилцагчийн үйлчилгээний стандарт
- СЭМҮТ “Стресс менежмент
- Доктор Жим Кэйнийн /Dr.Jim Cain/ “Teamwork&Teamplay” сургалт
- “APRC-2023” Ази, Номхон далайн орнуудын зах зээлийн судалгааны байгууллагуудын XV чуулган


ДИЖИТАЛЧЛАЛ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Сургалт, хөгжлийн цогц моделийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сургалт, хөгжлийн оновчтой хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, байнгын тасралтгүй сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Ажилтнуудынхаа сургалт, хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын үр өгөөжийг тооцож, хэмжиж эхлэв. Сургалтын үр өгөөжийг тооцоолон цаашдын сайжруулах шаардлагатай процесс болон асуудлуудыг тодорхойлон үүний үр дүнд компанийн гүйцэтгэл, бүтээмжид эергээр нөлөөлж эхлэв.



Дижитал шилжилт, цахимжилтын эрин үед бид цаг үетэйгээ хөл нийлүүлэн технологийн шийдэл, цахим сувгуудыг нээж ажиллуулж байгаатай холбоотой харилцагчдын мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь бидний нэн тэргүүний зорилт билээ.



Даатгалын үндсэн системийн санхүүгийн мэдээллийг Odata протокол ашигласнаар PowerBI дахь тайлангийн шинэчлэгдэх хугацааг 288 дахин хурдасгав.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖИЛ

Манай компани байгуулагдсан цагаас хойш салбартаа шинэлэг шийдлийн нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй сайжруулж, харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энгийн, хялбар ойлгомжтой байдлыг тэргүүнд тавьж харилцагч төвтэй бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхээр зорьж байна. Үүний дагуу компанийн бизнес хөгжил, борлуулалтын бодлого нь бүтээгдэхүүний чанар, зах зээлд өрсөлдөх чадвар болон даатгуулагчдад хүргэх борлуулалтын сувгийг гүр ашигтайгаар шийдэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Бид иргэд болон байгууллагуудад зориулсан Монгол дахь даатгалын бүх төрлийн үйлчилгээний хүрээнд 15 төрлийн 70 гаруй үйлчилгээг иргэд, харилцагчдынхаа хүсэл хэрэгцээнд нийцүүлэн даатгалын хамгийн өргөн сүлжээгээр хүргэж байна.

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол эмчилгээний даатгал



Хөрөнгийн даатгал



Автомобильн хэрэгслийн даатгал



Хүртээмжтэй даатгал



Мал, амьтдын даатгал



Жолоочийн хариуцлагын даатгал

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол эмчилгээний даатгал



Хөрөнгийн даатгал



Автомобильн хэрэгслийн даатгал



Хариуцлагын даатгал



Газар тариалангийн даатгал



Агаарын хөлгийн даатгал



Ачааны даатгал



Барилга угсралтын даатгал



Санхүүгийн даатгал



Итгэлцлийн даатгал



Агаарын хөлгийн өмчлөх эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал

2023 онд компанийн шинэчилсэн бодлого, даатгалын зах зээл, харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн даатгалын голлох бүтээгдэхүүнүүдийн андеррайтингийн нөхцөлийг сайжруулж, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулснаар бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, хэрэглээг нэмэгдүүллээ. Мөн тээврийн хэрэгсэл даатгуулж буй иргэдийг урамшуулах, борлуулалтыг дэмжих зорилгоор хөтөлбөр, аян зохион байгуулан ажиллаа.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Даатгалын бизнесийн мөн чанар нь нийгэмдээ чиглэсэн буюу аливаа эрсдэл учирсан үед тулгарч болох санхүүгийн эрсдэлээс хамгаалдаг боловч бид даатгалын боловсролыг багш сурган хүмүүжүүлэгчид, ирээдүйн бяцхан харилцагчдадаа олгох, мэдлэгийг нэмэгдүүлэх, одоо байгаа харилцагчдаа эрсдэлээс хамгаалах зорилгоор дараах хамтын ажиллагааг хэрэгжүүлэн нийгмийн хариуцлагаа биелүүлэн ажиллаа.



НЭГ ЗАМ НЭГ СОЁЛ АЯН

Нийгмийн хариуцлагын хүрээнд **"НЭГ ЗАМ, НЭГ СОЁЛ"** үндэсний хөдөлгөөнд бид бүхэн сайн дураар нэгдэж, Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс болон аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран өдөрлөг зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгөөр хол замд яваа жолооч нарын алжаал ядаргааг тайлж, хөгжөөнт тоглоом тоглуулан, гарын бэлгээр шагнаж, эрүүл мэндийн үзлэг хийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлсэн юм.



ТЭРБУМ МОД

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд манай байгууллага жил бүр нэгдэн, мод тарьж ургуулдаг билээ. "Мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан энэ удаад СХД-ийн 21-р хороонд байрлах "Ийнчөөн Мөрөөдлийн Төгөл"-д бид 100 гаруй ширхэг мод тарьсан юм.



ДААТГАЛЫН ӨДӨРЛӨГ

Монгол Даатгал Хувьцаат Компани харилцагч нартаа зориулсан даатгалын мэдлэг олгох өдөрлөгийг 21 аймаг болон хотын дүүргүүдэд зохион байгуулав.



ХИЧЭЭХ ӨДӨР


Замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцсоноор өдөрт учирч болох эрсдэлийг бууруулах зорилтын хүрээнд Төв аймгийн Замын цагдаагийн тасагтай хамтран **"Хичээх өдөр"** аянд Монгол Даатгал Хувьцаат Компани нэгдэв.



МОНГОЛ ДААТГАЛ

ИТГЭЛ ДААХ 90 ЖИЛ

ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ
ИЛҮҮ ХЯЛБАР,
ИЛҮҮ ХУРДНААР



 **1800-1990**
ДААТГАЛЫН ЛАВЛАХ


ТӨВ БАЙР:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороо, үндсэн хуулийн гудамж 32

ЦАХИМ ХАЯГ:

Цахим хуудас: www.mongoldaatgal.mn
Цахим шуудан: insurance@mongoldaatgal.mn

Facebook: [/mongoldaatgal](https://www.facebook.com/mongoldaatgal) JSC
Twitter: [/mongoldaatgal](https://twitter.com/mongoldaatgal) JSC



**“Монгол Даатгал” ХК-ийн
2023 оны санхүүгийн
аудитлагдсан тайлан**



AUDITING, ADVISORY, ASSURANCE

“ФИСКАЛ АУДИТ” ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот-14250

Сүхбаатар дүүрэг 4-р хороо, Сөүлийн гуудамж 23

Түшиг төв 505 тоот

Утас/факс: (976)-70106099, 99117709, 99991914

E-mail:

03.22.2024 № 3А-02/2023**“МОНГОЛ ДААТГАЛ” -ХК-ИЙН
УДИРДЛАГАД****ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН****Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан**

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа түсгээ дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн талаархи компаний удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

бүртгэлийн зохих бодлогыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилсан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг толорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдалд байгаа эсэхийг тодорхойлсон.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компаний тухай хууль"-ийн 5-р зүйл заасан хуулийн этгээд болох "МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ  ДАЛТАНТӨГС





“Монгол Даатгал” ХК
2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан
(Төг)

	<u>2022/12/31</u>	<u>2023/12/31</u>
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,229,129,022.6	4,855,669,054.6
Дансны авлага	2,365,557,680.5	1,797,459,970.6
Татвар, НДШ-ийн авлага	33,074,857.4	33,936,329.0
Бусад авлага	7,061,092,948.5	2,037,859,825.5
Бусад санхүүгийн хөрөнгө	7,210,277,844.3	5,764,116,430.7
Бараа материал	408,730,182.6	448,029,828.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	780,007,796.1	643,603,589.1
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>20,087,870,332.0</u>	<u>15,580,675,027.4</u>
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8,608,750,053.5	8,580,690,826.9
Бист бус хөрөнгө	1,364,971,453.1	1,373,596,903.1
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт	7,421,335,238.3	9,557,457,894.6
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>17,395,056,744.9</u>	<u>19,511,745,624.5</u>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u><u>37,482,927,076.9</u></u>	<u><u>35,092,420,651.9</u></u>

Захирал  Д.Алтантөг

Аудитын ажлын гүйцэтгэгч  Я.Батжаргал/ТМЗ/

Аудитор  Н.Мягмаржав

Аудитор  Н.Болорцэцэг

Аудиторын туслах  М.Шийдэрноров



“Монгол даатгал” ХК
2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан санхүүгчийн байдлын тайлан
(Төг)

	<u>2022/12/31</u>	<u>2023/12/31</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
Богнио хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	3,345,037,857.7	2,747,563,674.1
Цалингийн өглөг	13,260,752.0	3,313,728.6
Татварын өглөг	404,884,087.5	630,164,253.1
НДШ-ийн өр	113,281.8	3,113,308.8
Банкны богнио хугацаат зээлийн өглөг		
Хүүний өглөг		372,924.5
Ногдол ашигийн өглөг		
Урьдчилж орсон орлого	514,380,375.6	415,070,953.1
Нөөц /өр төлбөр/		
Бусад богнио хугацаат өр төлбөр	503,064,966.1	741,994,828.8
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
Богнио хугацаат өр төлбөрийн дүн	4,780,741,320.6	4,541,593,671.0
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Нөөц /өр төлбөр/	18,457,623,456.4	17,868,534,322.5
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	18,457,623,456.4	17,868,534,322.5
Нийт өр төлбөрийн дүн	23,238,364,777.0	22,410,127,993.5
Эзэмшигчийн өмч		
Эзний өмч /хувийн/	6,413,234,100.0	6,413,234,100.0
Халаасны хувьцаа	(9,857,124.0)	(9,857,124.0)
Нэмж төлөгдсөн капитал	4,522,649.1	4,522,649.1
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,038,875,843.2	7,038,875,843.2
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг / алдагдал /	797,786,831.6	(764,482,809.9)
Эзэмшигчийн өмчийн нийт дүн	14,244,562,299.9	12,682,292,658.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	37,482,927,076.9	35,092,420,651.9



“ФИСКАЛ АУДИТ” ХХК

Захирал

Д.Алтантөгс

Аудитын ажил гүйцэтгэсэн:

Аудитор

Я.Батжаргал/ТМЗ/

Аудитор

Н.Мягмарцэрэн

Аудитор

Н.Болорцэцэг

Аудиторын туслах

М.Шийдэрноров



MONGOL AUDIT ULC

“Монгол Даатгал” ХК
2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төг)

	<u>2022/12/31</u>	<u>2023/12/31</u>
Борлуулалтын орлого (цэвэр)	27,195,805,568.6	30,409,760,701.5
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	15,654,472,170.8	20,695,637,597.5
Нийт ашиг/алдагдал	11,541,333,397.8	9,714,123,103.9
Түрээсийн орлого	125,320,235.0	135,747,930.9
Хүүний орлого	13,499,477.0	678,256,335.4
Ногоол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого	507,099,645.4	382,586,780.5
Бусад орлого	397,178,609.0	44,094,346.6
Борлуулалт,маркетингийн зардал	8,016,726,564.1	8,077,735,039.0
Ерөнхий ба удирдлагын зардал	3,708,933,793.7	3,969,085,397.2
Санхүүгийн зардал	16,887,178.1	26,956,735.7
Бусад зардал	570,820,670.5	171,707,185.2
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	55,963,098.1	20,549,725.0
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	7,781,818.2	29,926,083.1
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	229,616,841.1
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	334,808,074.2	(1,469,816,892.9)
Орлогын татварын зардал	168,737,702.4	92,432,748.6
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	166,070,371.7	(1,562,269,641.5)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	166,070,371.7	(1,562,269,641.5)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	166,070,371.7	(1,562,269,641.5)
Нөгж хувианаа ногоох суурь ашиг (алдагдал)	-	-

"ФИСКАЛ АУДИТ" ХХК

Захирал		Д.Алтантөгс
Аудитын ажил гүйцэтгэгч:		Я.Батжаргал/ТМЗ/
Аудитор		Н.Мягмарцэрэн
Аудитор		Н.Болорцэцэг
Аудиторын туслах		М.Шиндэрноров



“Монгол Даатгал” ХК
2023 оны 12-р сарын 31-ний өдөр өрх
Аулигдсан өмчийн өөрчлөлтийн тайлан
(Тогт)

Агуулга	Хувьцаа эзтгэл	Халаасны хувьцаа	Нэмж тоологдсон кешит	Дахин үзэгдэлтэй нэмэгдэл	Эдийн өмчийн буцаа хэсэг	Хуримтлагдсан ашиг / алдагдал	Дүн
оны 01-р сарын 01-ний үзэгдэл	6,413,234,100.0	(9,857,124.0)	4,522,649.1	7,038,879,843.2	-	797,786,831.6	14,244,562,209.9
ин бодох бүртгэлийн боллоосны далгийн нөлөө, алаасны заруула	-	-	-	-	-	-	-
Урван үзэгдэл	6,413,234,100.0	(9,857,124.0)	4,522,649.1	7,038,879,843.2	-	797,786,831.6	14,244,562,209.9
инт үеийн нэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-
Азэлжээгүй орлого	-	-	-	-	-	-	-
А гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
Асан ноглол ашиг	-	-	-	-	-	-	-
и үндэстний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-	-
оны 12-р сарын 31-ний үзэгдэл	6,413,234,100.0	(9,857,124.0)	4,522,649.1	7,038,879,843.2	-	797,786,831.6	14,244,562,209.9
ин бодох бүртгэлийн боллоосны далгийн нөлөө, алаасны заруула	-	-	-	-	-	-	-
Урван үзэгдэл	6,413,234,100.0	(9,857,124.0)	4,522,649.1	7,038,879,843.2	-	797,786,831.6	14,244,562,209.9
инт үеийн нэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	11,562,269,641.5	(1,562,269,641.5)
Азэлжээгүй орлого	-	-	-	-	-	-	-
А гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
Асан ноглол ашиг	-	-	-	-	-	-	-
и үндэстний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-	-
оны 12-р сарын 31-ний үзэгдэл	6,413,234,100.0	(9,857,124.0)	4,522,649.1	7,038,879,843.2	-	(764,482,809.9)	12,682,292,678.5

ФИСКАЛ АУДИТ ХХК

Захирагч Д.Алтантөгс
Аулигч Я.Батсүрэгт / ГМЗ
Аулигч Н.Мянгалар / Фан
Аулигч Н.Болорсэлэн
Аулигч М.Шинэчир / Орхос

Аулигч туслах
Аулигч туслах



“Монгол Даатгал” ХК
2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

(Төг)

	<u>2022/12/31</u>	<u>2023/12/31</u>
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	267,823,244.25	2,537,488,258.26
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн	(459,481,695.51)	89,051,773.66
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,800,000.00)	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(253,458,451.26)</u>	<u>2,626,540,031.92</u>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>2,482,587,473.90</u>	<u>2,229,129,022.64</u>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>2,229,129,022.64</u>	<u>4,855,669,054.56</u>

“ФИСКАЛ АУДИТ” ХХК

Захирал


 Д.Алтантөгс

Аудитор


 Я.Батжаргал/ТМЭ/


Аудитор


Н.Мягмарцэрэн

Аудитор

Н.Болорцэцэг

Аудиторын туслах


 М.Шийдэрноров



**“Монгол Даатгал” ХК-ийн
2023 оны санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлт**



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 24/07

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.1, 96.5 дахь заалт, "Монгол Даатгал" ХК-ийн "Компанийн Дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн санал хураасан дүнг тус тус үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг энэ тогтоолын Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. 2023 оны санхүүгийн тайланд "Фискал Аудит" ХХК-иас гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
3. Энэхүү дүгнэлтийг 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг хурлын дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Аюушд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ТРОМОВ С.Б.



Бүхэлтэсний утас: 9953-3993
Даргачийн гэрээг: 9953-1000-7970



www.mongolbank.mn
@mongolbank.mn

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 24/07 тоот тогтоолын Хавсралт №01

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2023 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хураангуй, санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлт дээр үндэслэн "Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ/-ийн зүгээс дараах дүгнэлтийг гаргасныг танилцуулж байна.

1. Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн талаар

Нийт даатгалын салбарын зах зээлийн талаар, компанийн өрсөлдөх чадвар, нийгэмд бий болгосон баялаг, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар зэрэг үзүүлэлтийг танилцуулъя.



	2021 он	2022 он	2023 он
Нийт хөрөнгө	37,046,870,911	37,482,927,077	35,092,420,652
Нийт хураамж	29,223,393,836	27,195,805,569	30,409,760,701
Даатгуулагчийн тоо	194,572	168,180	185,525
Нөхөн төлбөр	8,778,213,456	7,495,068,520	7,713,057,803
Системд эзлэх хувь	13%	8.1%	7.8%
НТ авсан даатгуулагчийн тоо	9,519	9,114	7,207
Нийт ажиллагсдын тоо	216	210	200

"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 24/07 тоот тогтоолын Хэвэргийн №01

Бүтээмж	135,293,489	129,503,836	152,048,804
---------	-------------	-------------	-------------

Он	ROE	ROA	ROI	Хохирлын харьцаа	Зардлын харьцаа	Хос харьцаа
2021	0.80%	0.30%	37.7%	56%	69%	125%
2022	1.20%	0.44%	5.0%	47%	77%	124%
2023	-12.3%	-4.45%	5.3%	48%	75%	123%

2. Санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн талаар

ТУЗ-өөс "Фискал аудит" ХХК аудитын компанийг сонгож ажиллаа. Компанийн хувьд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалын дагуу гарган зохих тайлбар тодруулгын хамт Сангийн яам, татварын байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн байна.

2023 онд ердийн даатгалын салбар нийт хураамж 30%, цэвэр хураамжийн дүн 25.6%-иар өссөн нь даатгалын салбарын өсөлтийн хурдтай байгааг илтгэж байна. Монгол Даатгал" ХК-ийн хувьд нийт хураамжийн орлого өмнөх оноос 11.8%-иар өсөж 30.4 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого, 17.4 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлого төвлөрүүлж, үүнээс 7.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож, нийт 1,5 тэрбум төгрөгийн өлдөгдөг ажилласан. Компанийн орлогын төлөвлөгөө биелэлт нийт хураамж 100%, цэвэр хураамжийн төлөвлөгөө биелэлт 91%-тай ажилсан.

Компанийн хувьцаа нь хөрөнгийн биржийн "II" самбарт байршдаг. Хувьцааны үнэ (2024-03-20-ны өдрийн байдлаар) 2550 төгрөгийн ханштай, компанийн зах зээлийн үнэлгээ 163,537,469,550.00 төгрөг байгаа бөгөөд цаашид хувьцааны үнэ буурах хандлагатай гэж үзэж байна.


Цаашид МУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, чиглэл арга хэмжээнүүдтэй уялдсан оновчтой, уян хатан стратеги, менежментийн бодлого баримтлан компанийн өрсөлдөх чадварыг сайжруулан салбарын өсөлтөөс хувь хүртэж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, дансны авлагыг бууруулах, хөрөнгийн зохистой харьцааг хангаж ажиллах нь зүйтэй.



**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны төсвийн санал**

**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ТӨСӨВ**

№	Зардлын зүйл	Сарын цалин,	Нийт төсөв,
1	ТУЗ-ийн гишүүд	660,000	31,680,000
2	ТУЗ-ийн дэргэдэх хрооодын хурлын цалин	100,000	3,200,000
3	Эчнээ санал хураалтын цалин	200,000	4,800,000
4	ТУЗ-ийн хуралтай холбоотой бусад зардал	3,000,000	3,000,000
Нийт төсөв		42,680,000	



**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүнд нэр дэвшигчдийн
танилцуулга**



Эцэг /эх/-ийн нэр:

Громов

Өөрийн нэр:

СЕРГЕЙ БОРИСОВИЧ

Төрсөн он: **1968 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0930167

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1985-1992 онд Сибирийн өнгөт металын судалгааны хүрээлэнгийн их сургууль, Инженер

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1994 - 2000 онд Транс Уорлд Аллюминиум компани, Нөөцийн газрын захирал
- 2001- 2016 онд Чингис хаан банк, ТУЗ-ийн дарга
- 2004 - одоог хүртэл Монгол Даатгал ХК, ТУЗ-ийн дарга



Эцэг /эх/-ийн нэр:

Огай

Өөрийн нэр:

НАТАЛЬЯ ЮРЬЕВНА

Төрсөн он: **1976 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0130813

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1993 - 1998 онд Эрхүү хотын гадаад хэлний дээд сургууль, Хэл зүйч
- 2006 - 2009 онд Плехановын нэрэмжит Эдийн засгийн академи,
Санхүүч

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2003 - 2005 онд Сибэкология, Худалдааны хэлтсийн дарга
- 2005 - 2016 онд Чингис хаан банк, Тусгай төслийн газар
- 2016 - одоог хүртэл Монгол Даатгал ХК, ТУЗ-ийн ажлын алба



Эцэг/эх/-ийн нэр:

Лхагважав

Өөрийн нэр:

ТӨР-ОД

Төрсөн он: **1973**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0132389

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1981-1991 онд Нийслэлийн 23 дугаар тусгай дунд сургууль
- 1991-1992 онд Монгол Улсын Их Сургууль, ШУА-ны Хууль зүйн сургалт, судалгааны Хүрээлэн
- 1992-1997 онд Энэтхэг Улсын Хууль зүйн Үндэсний Их Сургууль, Улс төр-Эдийн засаг бакалавр, Хууль зүйн бакалавр
- 1998 онд ИБУИНВУ-ын Оксфордын Их Сургууль, Олон улсын хүний эрхийн хууль зүй дамжаа
- 2002 онд Норвеги Улсын Осло хот дахь НҮБ Ардчилсан засаглалын Төв, Төрийн захиргааны шинэтгэл судалгааны дамжаа
- 2003-2004 онд АНУ-ын Нью Йорк дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Виртуаль Академи
- 2007 онд Люксембургийн Их Сургууль, Банкны удирдлага, манлайллын хөгжилт хамтарсан дамжаа
- 2005-2006 онд Лондон Их Сургуулийн Дорно дахин, Африк судлалын сургууль, Олон улсын хууль зүй, Хөгжлийн эдийн засгийн Хууль зүйн магистрийн онц зэрэг

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1997-1999 онд Хууль зүйн яам, Зээл тусламж, төсөл хөтөлбөр, олон улсын байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн
- Олон улсын эрх зүйд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Банк санхүү, гадаадын хөрөнгө оруулалт, гаалийн хууль тогтоомж хариуцсан мэргэжилтэн
- 1999-2005 онд Монгол улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн захиргааны шинэтгэл, авлигалын эсрэг, хүний эрх, шүүх эрх мэдлийн шинэтгэлийн багц асуудлыг эрхэлсэн Засаглалын хөтөлбөрийн удирдагч
- Засаглал, хүний эрхийн асуудал хариуцсан референт
- Эдийн засгийн шилжилт, засаглалын асуудал хариуцсан шинжээч
- 2005-2011 онд Хас банк, Гүйцэтгэх дэд захирал
- Хууль зүй, Хянан нийцүүлэх газрын захирал
- Тамгын газрын захирал
- Банкны зөвлөх бөгөөд Лондон дахь төлөөлөгч
- 2010-2011 онд Хас банк түүний толгой компани Тэнгэр санхүүгийн нэгдэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн ерөнхий зөвлөх бөгөөд компанийн нарийн бичгийн дарга
- 2011-2012 онд Монголын эдийн засгийн форум, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий захирал,
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх
- 2012-2012 онд Монголын банкны холбоо, Гүйцэтгэх захирал бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга
- 2012-2013 онд Ерөнхийлөгчийн тамгын газар, Хууль зүйн яам, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль зүйн асуудал хариуцсан шадар туслах, Хууль зүйн сайдын зөвлөх
- 2014-2017 онд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга
- 2013 оноос одоог хүртэл Транспарэнси интернэшнл-авлигатай тэмцэх олон улсын байгууллагын Монгол дахь салбар, Гүйцэтгэх захирал, Удирдах зөвлөлийн дарга
- 2014-2016 онд Өмнөд ба Зүүн Ази дахь Орон нутгийн засаглалын санаачилга сүлжээ, Монгол дахь үндэсний зохицуулагч, хамтран үүсгэн байгуулагч
- 2015 оны 1 дүгээр сараас Азийн Ардчилалын сүлжээ, Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд хамтарсан тэргүүн, Зүүн ойд Төв Ази дэд бүс нутгийн төлөөлөгч
- 2016-2019 онд Олон улсын Олборлох Үйлдвэрлэлийн санаачилга иргэний нийгмийн Төлсөн Авснаа Нийтэл, Дэлхийн зөвлөлийн гишүүн бөгөөд Еврази бүс нутгийн төлөөлөгч, Үндэсний зрхицуулагч
- 2017 оны 7 дугаар сараас Олон Улсын Нээлттэй засаг түншлэл, Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд Ази-Номхон далайн бүс нутгийн төлөөлөгч
- 2019 оны 6 дугаар сараас Тогтвортой хөгжлийн төлөөх Азийн иргэний нийгмийн түншлэл, Ерөнхий зохицуулагч
- 2018 оны 5 дугаар сараас Ази-Европын Ард түмний форум-АСЕМ, Олон улсын зохион байгуулах хорооны байнгын гишүүн



Эцэг/эх/-ийн нэр:

Лизунова

Өөрийн нэр:

ТАНЯ

Төрсөн он: **1983**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

00279

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1990 - 2000 онд ОХУ, ЭСЯ-ны дэргэдэх дунд сургууль Бүрэн дунд
- 2000 - 2004 онд МУИС Эдийн Засгийн Сургууль Банк санхүү бакалавр

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2006 - 2016 онд “Чингис Хаан” банк ТУЗ-ийн даргын туслах
- 2016 - одоог хүртэл Монгол Даатгал” ХК ТУЗ-ийн ажлын алба

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1989-1997 онд Монгол Оросын хамтарсан 3-р дунд сургууль
- 1997-1999 онд Киргиз Улсын Бишкек хотын 24-р дунд сургууль
- 1999-2003 онд Киргиз Улсын Бишкек хот дахь Төв Азийн Америкийн Их Сургууль, Бизнес удирдлагын бакалавр
- 2004-2005 онд БНХАУ-ын Бээжин хот дахь Олон улсын бизнес, эдийн засгийн их сургууль, Эдийн засгийн магистр
- 2005-2006 онд БНХАУ-ын Бээжин хот дахь Хэл, соёлын их сургууль, Хятад хэлний түргэвчилсэн сургалт
- 2007 онд АНУ-ын Пенсилвани мужийн Лихай их сургууль, Олон улсын бизнесийн манлайллын сургалт
- 2010 онд Швейцарийн Холбооны Улсын Женев хот дахь Дэлхийн худалдааны байгууллагын дадлагажигчийн хөтөлбөр
- 2014 онд Английн Империл коллеж, Уул уурхай, уул уурхайн санхүүжилт дамжаа
- 2015 онд ӨАБНУ-ын Йоханнесбург хот дахь Преториагийн Их Сургуулийн Гордоны бизнесийн ухааны сургууль, Удирдлагын манлайллын дамжаа

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2003-2004 онд Худалдаа, хөгжлийн банк, Үйл ажиллагаа хариуцсан захирлын туслах, орчуулагч
- 2006-2007 онд Монтулга ХХК, Гадаад харилцааны менежер
- 2007-2008 НҮБ-ын ХХААБ-ын Монгол Улс дахь техникийн хамтын ажиллагаа төсөл (Монгол Улсын ҮХЯ-тай хамтарсан төсөл)-д Төслийн зохицуулагч
- 2008 онд Үйлдвэр, худалдааны яам, ГХЭЗХАГ-ын Хойд Америк, Латин Америк хариуцсан худалдаа, эдийн засгийн мэргэжилтэн
- 2008-2011 онд Гадаад харилцааны яам, ГХЭЗХАГ-ын Хойд Америк, Латин Америк хариуцсан худалдаа, эдийн засаг хариуцсан атташе
- 2011-2012 онд Монгол Улсаас Австрали Улсад суугаа ЭСЯ-ны 3 дугаар нарийн бичгийн дарга, Консулын ажилтан
- 2013-2016 онд Англо Американ Девелопмент ХХК, Зах зээл шинжээч
- 2017 онд ЕХ-ны Худалдааг дэмжих төсөл, богино хугацааны зөвлөх
- 2017 оны 11 сараас Монгол Даатгал ХК, Эрүүл мэндийн даатгал хариуцсан дэд захирал
- 2024 оны 3 сараас Гүйцэтгэх захирлын орлогч



Эцэг /эх/-ийн нэр:

Гантөмөр

Өөрийн нэр:

ГАНЖАРГАЛ

Төрсөн он: **1981 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0132536



Эцэг/эх/-ийн нэр:

Баяртогтох

Өөрийн нэр:

ЭНХБАЯР

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Япон, Орос

Компанийн засаглалын
гэрчилгээний дугаар:

0520013

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- Японы Хитоцубашигийн Их Сургууль, Эдийн засагч бакалавр, магистр

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2005-2008 онд Deutsche Bank, Global Markets, Токиогийн хөрөнгийн бирж дэх хувьцааны багцийн арилжаа хариуцсан трейдр, дилер
- 2012-одоог хүртэл “Би Ди Сек” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
- 2009-одоог хүртэл Sanaa EXE, Ulaanbaatar, Гүйцэтгэх захирал



Эцэг /эх/-ийн нэр:

Базар

Өөрийн нэр:

АЮУШ

Төрсөн он: **1953 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

20090603

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1961-1971 онд Нийслэлийн 24 дүгээр дунд сургууль
- 1971-1974 онд Монгол улсын их сургууль, Эдийн засаг бакалавр
- 1988-1992 онд Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн академи, Эдийн засгийн ухааны доктор
- 2009-2011 онд Түшээ дээд сургууль, Эрх зүйч

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1974-1977 онд ТТХЕГ, Орлогч ня-бо
- 1977-1995 онд Монгол улсын их сургууль, Багш
- 1995-2006 онд Үнэт цаасны хороо, Хэлтсийн дарга
- 2006-2010 онд Санхүүгийн зохицуулах хороо, Газрын орлогч дарга
- 2010-2013 онд Санхүүгийн зохицуулах хороо, Даргын орон тооны бус зөвлөх
- 2013-одоог хүртэл Мандах дээд сургууль, Зөвлөх профессор
- 2017-2019 онд ДиБиЭм ассет менежмент, Ахлах аудитор
- 2019-одоог хүртэл Райнос ассет менежмент, Ахлах аудитор



Эцэг /эх/-ийн нэр:

Зориг

Өөрийн нэр:

ХАЙДАР

Төрсөн он: **1979 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0131753

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 2000 онд Санхүү, Эдийн засгийн Их сургууль, Банк санхүү бакалавр
- 2003 онд Handong Global University, Өмнөд солонгос ба Монголын Санхүү Эдийн Засгийн Их сургууль, Олон улсын бизнесийн удирдлага магистр
- 2006-2015 онд Multiple trainings organized by International payment associations

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1999-2001 онд Credit Union, Гүйцэтгэх захирал
- 2001 оны 1 дүгээр сараас 5 дугаар сар хүртэл Хас ББСБ, Ахлах эдийн засагч
- 2001 оны 7 дугаар сараас 2001 оны 9 дүгээр сар хүртэл Нетмон ББСБ, Гүйцэтгэх захирал
- 2001-2002 онд Инвеском ББСБ, Зээл, үйл ажиллагаа хариуцсан менежер
- 2002-2003 онд Голомт банк, Зээлийн мэргэжилтэн
- 2003-2005 онд Голомт банк, Ахлах зөвлөх
- 2005-2006 онд Монголын зээл хөгжүүлэлтийн хөтөлбөр, Зээлийн үйлчилгээний зөвлөх
- 2006-2007 онд Худалдаа Хөгжлийн Банк, Захирал
- 2008-2009 онд Phongsavanh bank /Vietaine, LAO P.D.R./, Дэд захирал
- 2010-2011 онд Хаан банк, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт/Бизнес санхүү газрын ахлах
- 2011-2014 онд Голомт банк, Цахим банк хариуцсан Захирал
- 2015-2016 онд 360 Finance NBFO, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
- 2017 оны 9 дүгээр сараас одоог хүртэл Монголын Лакросс холбооны үүсгэн байгуулагч бөгөөд ерөнхийлөгч
- 2017 оны 1 дүгээр сараас одоог хүртэл MasterCard international байгууллагын Монгол дахь зөвлөх



Эцэг /эх/-ийн нэр:

Сиваев

Өөрийн нэр:

**АЛЕКСАНДР
ВЛАДИМИРОВИЧ**

Төрсөн он: **1977 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0930191


“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1995-2000 онд Красноярскийн Улсын Их сургууль, Хууль, эрх зүйч
- 1997-1999 онд Сибирийн Сансар Судлалын академи, Эдийн засаг, менежмент
- 2009-2014 онд Institute of Directors in London, Chartered Directors Programm

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2001-2003 онд Русал, Шинэ төслийн хэлтэс
- 2003-2003 онд Русал, Санхүүгийн дарга
- 2003-2004 онд Русал, Төслийн удирдагч
- 2004-2005 онд Русал, Санхүү төсвийн хэлтэс
- 2005-одоог хүртэл Красный Яр, Ерөнхий захирал



**“Монгол Даатгал” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын тооллогын комиссын
ТОГТООЛЫН ТӨСӨЛ**



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 24/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, хурлын ирцийг бүртгэсэн дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлсэн нь нийт гаргасан энгийн хувьцааны хувь болж байгааг хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх заалт болон компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

КОМИССЫН ДАРГА

Ө.ЭРДЭНЭБИЛЭГ





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

20 24 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 24/02

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдээлсүгэй:
 - "Монгол Даатгал" ХК-ийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай нийт өгсөн саналын тоо, үүнээс татгалзсан, зөвшөөрсөн, нийт саналын эрхийн хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.
 - "Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай нийт өгсөн саналын тоо, үүнээс татгалзсан, зөвшөөрсөн, нийт саналын эрхийн хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.
 - "Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай нийт өгсөн саналын тоо, үүнээс татгалзсан ..., түдгэлзсэн ..., зөвшөөрсөн, нийт саналын эрхийн ... хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.

КОМИССЫН ДАРГА


Ө.ЭРДЭНЭБИЛЭГ



Булган даатгал: +975 1603-1560
Дэлхийн харилцаа: +975 1610-1000



www.mongoladaatgal.mn
info.taarim@mongoladaatgal.mn



**“Монгол Даатгал” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлаас гарах тогтоолын
төслүүд**



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 24 оны 04 сарын 29 өдөр

Дүгээр 24 /01

Утасчлолтой хэл

Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.9 дэх заалт, "Монгол Даатгал" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.1 дэх заалт, 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.
2. 2024 онд Компанийн ашгийг намэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АЮУШ



Булган дугаар - 90 300-0990
Цэвэрлэн - туслах - 975 100-4990



www.mongoldevelopment.mn
info@mc@mongoldevelopment.mn



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ЛН 24 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 24102

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.13 дахь заалт, "Монгол Даатгал" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.5 дахь заалт, 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

- "Монгол даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ТУЗ-ийн дарга /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АЮУШ



Улаанбаатар | 1521010-1900
Дэлгэрэн лавих | 1521010-1900



www.mongoldaatgal.mn
hr@daatgal.mongoldaatgal.mn



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарны 29 өдөр

дугаар 24/03

Йвэлбианар хэт

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:
 - 1.
 - 2.
 - 3.
 - 4.
 - 5.
 - 6.
3. Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:
 - 1.
 - 2.
 - 3.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д даалгасугай.
5. Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б. АЮУШ



Булган дотгооли - 976 7010 1990
Булган дотгооли - 976 803 1990



www.mongoldatgal.mn
info@mongol.mongoldatgal.mn



МОНГОЛ ДААТГАЛ
ИТГЭЛ ДААХ *90* ЖИЛ

ТӨВ БАЙР:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороо, үндсэн хуулийн гудамж 32

ЦАХИМ ХАЯГ:

Цахим хуудас: www.mongolmaatgal.mn
Цахим шуудан: insurance@mongolmaatgal.mn

Facebook: [/mongolmaatgal JSC](https://www.facebook.com/mongolmaatgal)
Twitter: [/mongolmaatgal JSC](https://twitter.com/mongolmaatgal)

 **1800-1990**
ДААТГАЛЫН ЛАВЛАХ